

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН

ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /БАГЦ-1 ДУГУЙТ НАСОС, БАГЦ-2 ГАЗОДЕТЕКТОР, БАГЦ-3 АВТОМАШИН ӨРГӨГЧ ТӨХӨӨРӨМЖ, ХАГАС АВТОМАТ ГАГНУУРЫН АППАРАТ/ НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер
шалгаруулалтын нэр
/дугаар:

*Газрын тусгай үйлчилгээний албаны тоног төхөөрөмж /Багц-1 Дугуйт насос, Багц-2 Газодетектор, Багц-3 Автомашин өргөгч төхөөрөмж, хагас автомат гагнуурын аппарат/ нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер.
ИНЕГ/УЗ/ТББ/Б-11/20*

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.04.30

Иргэний нисэхийн ерөнхий газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Газрын тусгай үйлчилгээний албаны тоног төхөөрөмж /Багц-1 Дугуйт насос, Багц-2 Газодетектор, Багц-3 Автомашин өргөгч төхөөрөмж, хагас автомат гагнуурын аппарат/ ИНЕГ/УЗ/ТББ/Б-11/20-ийг** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 05-р сарын 11-ний 14.00 цаг-аас өмнө Засгийн газрын худалдан авах цахим систем [/www.tender.gov.mn/](http://www.tender.gov.mn) цахим хуудсанд цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 05-р сарын 11-ний өдрийн 14.30 цагт нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар болон www.tender.gov.mn цахим хуудаснаас авч болно.

Улаанбаатар хот. Буянт-Ухаа. Иргэний нисэхийн ерөнхий газар.

ХААТасаг. 108 тоот өрөө.

Утас: 71-282127

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | |
|---|--|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ. |
| 3. Тендерийн иж бүрдэл | 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
(а) Үнийн санал;
(б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.] |
| 4. Тогтмол үнэ | 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна. |

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: /Төсөвт өртгийн 50%-тай тэнцүү дүнгээр ирүүлнэ/ 2. Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 1 жил. 3. Туршлагын мэдээлэл /гэрээ дүгнэсэн акт эсхүл ажил хүлээн авсан баримт/: Сүүлийн 1 жил. 4. Ижил төстэй ажлын гэрээний үнийн дүн нь уг тендерийн төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна: Сүүлийн 1 жил. 5. Борлуулалтын орлого: Төсөвт өртөгийн 100 хувьтай тэнцүү
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: [Улаанбаатар хот, ХУД-ын 21-р хороо Иргэний нисэхийн ерөнхий газар] Давхар болон өрөөний дугаар: [Худалдан авах ажиллагааны тасаг 1 давхар, 108 тоот] Огноо: [2020 оны 05 дугаар сарын 11-ний өдөр] Цаг: [14 цаг 00 минут]</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: [Улаанбаатар хот, ХУД-ын 21-р хороо Иргэний нисэхийн ерөнхий газар] Давхар болон өрөөний дугаар: [Худалдан авах ажиллагааны тасаг 1 давхар, 108 тоот] Огноо: [2020 оны 05 дугаар сарын 11-ний өдөр] Цаг: [14 цаг 30 минут]</p>
ТӨӨЗ 2.3	<p>Дээрхи маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт 2. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт 3. Нийгмийн даатгалын өр төлбөргүй талаарх цахим тодорхойлолт 4. Татварын албаны цахим тодорхойлолт /тендер нээсэн өдрийн байдлаар өр төлбөргүй байх/ 5. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 6. Тухайн байгууллагыг төлөөлсөн этгээдийг томилсон байх.
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Газрын тусгай үйлчилгээний албаны тоног төхөөрөмж /Багц-1 Дугуйт насос, Багц-2 Газодетектор, Багц-3 Автомашин өргөгч төхөөрөмж, хагас автомат гагнуурын аппарат/ ИНЕГ/УЗ/ТББ/Б-11/20</p>

Дөрөв: **БАРАА НИЙЛҮҮЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА,
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

АГУУЛГА

1. Барааны нэр төрлийн жагсаалт болон нийлүүлэлтийн хуваарь
2. Холбогдох үйлчилгээний жагсаалт болон гүйцэтгэлийн хуваарь
3. Техникийн тодорхойлолтыг хавсралт хүснэгтээс үзнэ үү.

ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ТӨВ ОРОН НУТГИЙН ШАТАХУУНЫ АГУУЛАХЫН ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ НАСОСНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолтод орон нутгийн нисэх буудлуудын шатахууны агуулахын засвар үйлчилгээнд шаардлагатай насосны техникийн шаардлага болон тоо хэмжээг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1. Нийлүүлэгчид тавигдах шаардлага

- 2.1.1. Нийлүүлэгч нь тухайн чиглэлээр нэгээс жилээс доошгүй жил үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай байна.
- 2.1.2. Үйлдвэрийн болон тээвэрлэлтээс үүдэлтэй үүсэн гэмтэл, шинж чанарын өөрчлөлт зэргийг бүрэн хариуцах, зөрчлийг арилгах чадамжтай байна.
- 2.1.3. Нийлүүлэгчийн зүгээс чанарын баталгаа гаргана.
- 2.1.4. Барааг өөрийн тээврийн хэрэгслээр эцсийн цэгт хүргэнэ.

2.2. Насосанд тавигдах шаардлага

- 2.2.1. Насосыг үйлдвэрлэснээс хойш ашиглаагүй, шинэ байх.
- 2.2.2. Үйлдвэрлэгчийн гаргасан бүтээгдэхүүний үндсэн үзүүлэлт болон хадгалалтын хугацаа, ашиглалтын заавартай байх
- 2.2.3. Насос болон түүний үйл ажиллагааны үндсэн параметруудийг агуулсан бичиг баримт
- 2.2.4. Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар байна.
- 2.2.5. Үйлдвэрийн хайрцаг сав, баглаа боодолтой байх.

2.3. Насосны тоо хэмжээ, үзүүлэлт

№	Бүтээгдэхүүний нэр	Үзүүлэлт	Тоо хэмжээ
2.3.1	Дугуйт насос	Урсгалын хурд – 500 л/мин дээш Сорох өндөр – 9 м дээш Эргэлтийн хурд – 1435-1450 Хүчдэл – 220,380 Вт Хүчин чадал – 4-6 кВт	1 иж бүрдэл

2. АВТОМАШИН ӨРГӨХ ТӨХӨӨРӨМЖИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Ерөнхий шаардлага

Автомашин өргөх төхөөрөмж нь ашиглалтын хувьд найдвартай, техникийн үйлчилгээ засварын ажил явуулахад хялбар, сайн чанарын материалаар хийгдсэн байна. Уг автомашин өргөх төхөөрөмж нь Монгол улсад мөрдөгдөж буй автоүйлчилгээ ангилалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5025-2010 стандарт бүрэн хангасан байна.

2. Үндсэн үзүүлэлт

- | | |
|------------------------|-------------------------------|
| - Өргөгчийн төрөл | 2 баганатай , 4 цэгээр өргөгч |
| - Өргөгчийн дамжуулга | Гинжит болон Тросстой |
| - Өргөх даацын хэмжээ | 3.5тн болон түүнээс дээш |
| - Цахилгаан хүчдэл | 380вольт/ 3Фаз |
| - Өргөх өндөр | 119-1960мм |
| - Багана хоорондын зай | 2454мм буюу түүнээс дээш |
| - Өргөх хугацаа | 52-60сек |
| - Цахилгаан мотор | 1.5кв |

3. Нэмэлт нөхцөл

- 4 цэгээр өргөгч хөлд 3 төрлийн өндөрлөгөө тус бүрт нь байх
- 4 цэгээр өргөгч хөл нь тэгш хэмтэй байх
- Автомашины хаалга гэмтээхээс хамгаалсан резинтэй байх
- Өргөх төхөөрөмжийг доош буулгах систем нь механик ажиллагаатай байх
- Босоо баганын суурь нэмэлт бэхэлгээтэй байх

4. Бусад нөхцөл

- Төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах
- Ашиглалтын гарын авлага болон техник үйлчилгээ засварын заавар, зэргийг англи хэлээр дагалдуулах.
- Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар байна.

3. ХАГАС АВТОМАТ ГАГНУУРЫН АППАРАТНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Ерөнхий шаардлага

Хагас автомат гагнуурын аппарат нь ашиглалтын хувьд найдвартай, техникийн үйлчилгээ засварын ажил явуулахад хялбар, сайн чанарын материалаар хийгдсэн байна.

2. Үндсэн үзүүлэлт

- | | |
|------------------------------|-----------------|
| - Гаралтын үйлдэл | 50-350А |
| - Удирдлага | Инвертер |
| - Оролтын тэжээл | 380В/50Гц/3Фаз |
| - Оролтын чадал | 12,6кВт |
| - Үйлдэл | СО2/МIG/MAG |
| - Утасны диаметр | 0,8/1,0/1,2 |
| - Хөргөлт | Агаарын хөргөлт |
| - Тасралтгүй ажиллах хугацаа | 60% |

3. Дагалдах хэрэгсэл

- Гагнуурын гар
- Утас дамжуулагч
- Хийн регулятор
- Хийн баллон
- MAG болон СО2 хий.

4. Бусад нөхцөл

- Төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах
- Ашиглалтын гарын авлага болон техник үйлчилгээ засварын заавар, зэргийг англи хэлээр дагалдуулах
- Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар байна.

4. ТӨВ ОРОН НУТГИЙН ШАТАХУУНЫ АГУУЛАХ, СУМЛАГЧ, ТЭЭВЭРЛЭГЧ АВТОМАШИНЫ ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭНД ШААРДЛАГАТАЙ ГАЗОДЕТЕКТОРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэ техникийн тодорхойлолтод орон нутгийн нисэх буудлуудын шатахууны агуулах, сумлагч, тээвэрлэгч автомашины засвар үйлчилгээнд шаардлагатай газодетекторын техникийн шаардлага болон тоо хэмжээг тусгасан болно.

2. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1. Нийлүүлэгчид тавигдах шаардлага

- 2.1.1. Нийлүүлэгч нь тухайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлсэн туршлагатай байна.
- 2.1.2. Үйлдвэрийн болон тээвэрлэлтээс үүдэлтэй үүсэн гэмтэл, шинж чанарын өөрчлөлт зэргийг бүрэн хариуцах, зөрчлийг арилгах чадамжтай байна.
- 2.1.3. Нийлүүлэгчийн зүгээс чанарын баталгаа гаргана.
- 2.1.4. Барааг өөрийн тээврийн хэрэгслээр эцсийн цэгт хүргэнэ.

2.2. Газодетекторт тавигдах шаардлага

- 2.2.1. Үйлдвэрлэснээс хойш ашиглаагүй, шинэ байх
- 2.2.2. Үйлдвэрлэгчийн гаргасан бүтээгдэхүүний үндсэн үзүүлэлт, ашиглалт болон засварын заавартай байх
- 2.2.3. Насос болон түүний үйл ажиллагааны үндсэн параметруудийг агуулсан бичиг баримт
- 2.2.4. Үйлдвэрийн хайрцаг сав, баглаа боодолтой байх.
- 2.2.5. Баталгаат засварын хугацаа нь ажил хүлээн авах комисс гарын үсэг зурж, хүлээн авснаас хойш 12 сар байна.

2.3. Насосны тоо хэмжээ, үзүүлэлт

№	Бүтээгдэхүүний нэр	Үзүүлэлт	Тоо хэмжээ
2.3.1	Газодетектор	Илрүүлэх хий – шатамхай хий (метан), хүчилтөрөгч, устөрөгчийн сульфид, нүүрс төрөгчийн дутуу исэл Илрүүлэх зарчим – автомат Ашиглалтын температур, чийгшил – (-10 - +40), 95% конденсацгүй Дэлгэц – гэрэлтүүлэг бүхий, бүх үзүүлэлтийг нэгэн зэрэг хянаж байхаар Цэнэг барих чадвар – 8 аас дээш цаг тасралгүй ашиглах боломжтой байх Анхааруулга өгөх хэлбэр – дуут болон гэрэл Овор хэмжээ - Ойролцоогоор. 152 (Өргөн) × 152 (Өндөр) × 42 (Диаметр) мм Ашиглалтын хэлбэр – ажил эхлэхийн өмнө болон ажил явагдаж байх үед мэдээллэх чадвартай байх	1 иж бүрдэл
2.3.2	Дагалдах хэрэгслүүд	Дээж авах хоолой – 8 метрээс ихгүй дээж авах хоолой, кабель хамгаалах зөөлөвчтэй	

5. БАРАА ХҮРГЭХ ЦЭГ

Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Буян-Ухаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа Газрын тусгай үйлчилгээний шатахуун хангалтын алба.

1. Бараа нийлүүлэлтийн хуваарь:

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

д/д	Материалын нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
ГАЗРЫН ТУСГАЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ							
1	Дугуйт насос	1	Иж бүрдэл	ИНЕГ	30	45	
2	Газодетектор	1	Иж бүрдэл	ИНЕГ	30	45	
3	Хагас автомат гагнуурын аппарат	1	Иж бүрдэл	ИНЕГ	30	45	
4	Автомашин өргөх төхөөрөмж	1	Иж бүрдэл	ИНЕГ	30	45	

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [1] жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [30] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. Иргэний нисэхийн ерөнхий газраас ажлын комисс томилон барааг хүлээж авна |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;4) барааны гарал үүслийн гэрчилгээ. <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | <p>3.1. Баталгаат засварыг 1 жилээр ирүүлнэ. Баталгаат засварын хугацаанд эвдрэл, үл тохирлыг нийлүүлэгчийн зардлаар засварлана.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p> |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | <p>4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none">2. Ирсэн барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлбөрийг төлнө.3. Баталгаат засвар гэрээний үнийн дүнгийн 5 хувь байна. Баталгааг засварын хугацаа дууссаны дараа чөлөөлнө. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | <p>5.1. Алданги оногдуулах хувь: [Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5%]</p> <p>5.2. Алдангийн нийт дүн: [Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 10%]</p> |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]